



## ТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын талаар

#### 1.1. Хууль зүйн шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тээврийн салбарын үйлчилгээг өргөтгөх, эрх зүйн орчинг шинэчлэх талаар 5.3-д “Дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчийн болон эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ. ..., бүс нутгийн зам, тээврийг хоёр хөрш, Ази, Европыг холбосон гүүр, тээвэр зуучлалын үйлчилгээ болгон шинэ түвшинд гаргана” гэж, мөн бодлогын 5.3.1-д “Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого”-ын хүрээнд “Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно: ... авто зам, тээвэр, иргэний нисэх, төмөр зам, усан замын тээврийн тухай хуулиуд, холбогдох стандартууд, дүрэм журмуудад өөрчлөлт оруулахын зэрэгцээ зарим хуулийг шинээр баталж мөрдүүлэх; олон улсын конвенци, стандарт шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн тээврийн гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчилж, олон улсад нийтээр дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох.” гэсэн зорилтуудыг тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Транзит Монгол” үндэсний хөтөлбөрийн 4-т “... Монгол Улс өөрийн газар зүйн давуу талыг ашиглан, зах зээлийн бодит хэрэгцээнд суурилсан, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвхтэй оролцоотой транзит тээвэр, логикийн салбарыг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэнэ” гэсэн зорилгын хүрээнд хөтөлбөрийн 4.1-д “Гадаад худалдаа, олон улсын тээвэр, логикийн үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилтыг хэрэгжүүлэхээр заасан.

Монгол улсын олон улс, бүс нутгийн хэмжээний тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох эрэлтэд үндэслэн Монгол Улс нэгдсэн орсон Олон улсын конвенц, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн нэгдсэн зохицуулалт хийх эрх зүйн орчинг бий болгох шаардлага гарч байна.

#### 2.1. Практик шаардлага:

Зам, тээврийн салбар нь эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий үүргийг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь микро түвшинд хүн ардын эдийн засаг, нийгмийн харилцаанд оролцох үйл хөдөлгөөнд хэрэглэгдэхээс эхлээд

аливаа бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өртөг, эдийн засгийн бүхий л салбарын үйл ажиллагааны үр ашиг, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зэрэгт, макро түвшинд үндэсний үйлдвэрлэх баялгын хэмжээ, хүн амын амьжиргааны түвшин, байгаль экологийн тэнцвэрт байдалд нөлөөлж байдаг.

НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн комиссоос гаргасан зөвлөмжид олон улсын худалдаа тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлснээр олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх боломж бүрдэнэ гэж заасан байдаг. Дэлхий нийтийн даяаршлын бодлогод нийцүүлэн бүс нутаг, цаашлаад олон улсад өрсөлдөхүйц бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, зах зээлд нийлүүлэхэд зам, тээврийн салбарын гүйцэтгэх үүрэг, зорилтыг шинэчлэн тодорхойлох шаардлага тулгараад байна.

Үүний тулд тодорхой арга хэмжээнүүдийг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд худалдаа, тээврийг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засаг, нийгмийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын зам, тээврийн салбарын өнөөгийн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтанд салбарын тулгамдсан нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, тээврийн шинэ төрлийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс тээврийн дэд бүтэц, тээврийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагыг үр ашигтай хангаж чадахгүйд хүрэх нөхцөл байдал үүсч байгаа зэрэг үндэслэл, шаардлагын дагуу “Тээврийн ерөнхий хууль”-ийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар**

Хуулийн төслөөр тээврийн салбарын үр ашигтай, тогтвортой хөгжил, тээврийн дэд салбаруудын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн хоорондын харилцан уялдааг хангахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна.

Зах зээлийн эрэлтэд нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий тээврийн үйлчилгээ, менежментийг цогц байдлаар хөгжүүлэх, хүн ам, хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн үр ашигтай, дэвшилтэд техник, технологи, тээврийн төрөл, тээврийн ухаалаг систем, уян хатан нэгдсэн үнэ тарифыг нэвтрүүлэх зарчмыг баримтална.

Хуулийн төсөл нийтлэг үндэслэл, зам, тээврийн үйл ажиллагааны үндсэн зарчим, тээврийн үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, тээврийн өмчлөл, тээврийн төрөл, үйл ажиллагааны хүрээ, тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эдийн засгийн зохицуулалт, нэгдсэн бодлого, төлөвлөгөө, зэргийг тодорхойлох, эрх зүйн байдал болон бусад харилцааг зохицуулсан ерөнхий бүтэцтэй байх бөгөөд дараах харилцааг зохицуулна.

Тээврийн аюулгүй, шуурхай, найдвартай, эрэлтэд нийцсэн, чанартай үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх үйл ажиллагааны чиглэл, зорилгыг шинээр тодорхойлох;

Салбарт шинээр бий болж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг даган нэвтэрч буй нэгдсэн нэр томъёог бий болгон хэрэглэх талаар;

Хөгжлийн ойрын зорилт нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх, дунд, алс хэтдээ зам, тээврийн салбар нь тэргүүлэх салбар болох зорилт, стратегийг хэрэгжүүлэх суурь, нөхцөлийг бүрдүүлэх талаар;

Бусад орнуудын шилдэг туршлага, ололтод технологи, инноваци, мэдлэгийг нутагшуулан, хөгжүүлэх чиглэлээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын жишиг, хандлагад ойртуулах, нийцүүлэх зорилгоор стандартчилал, тохирлын үнэлгээ, хэм хэмжээг тогтоон хэрэгжүүлэх талаар;

Тээврийн салбарын удирдлагын тогтолцоо, тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон холбогдох бусад байгууллага, нэгжийн бүрэн эрх, чиг үүргийн талаар;

Тээврийн салбарын үйл ажиллагааны оновчтой, зөв байх нөхцөлийг хангах, мэргэжлийн ажил гүйцэтгэж буй ажилтан албан хаагчид, харъяа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлагаар хангаж байх, шинэ техник, технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж байх зорилгоор салбарын сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын хэв шинжийг тодорхойлох;

Тээврийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг оновчтой, үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулах, эрсдэл, алдагдлын менежментийг сайжруулах, хамтран ажиллах, харилцан ашигтай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх боломжийг бий болгох;

Төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүртээмжтэй, чанартай хүргэх, холбогдох зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг шинэ шатанд гаргаж, нээлттэй, ил тод болгох нөхцөлийг бүрдүүлэх;

Салбар бүхэлдээ эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн хөдөлгөгч хүч нь байхын зэрэгцээ төсвийн ачааллыг багасгах, тогтвортой, найдвартай санхүүжилтийн тогтолцоог бий болгож хэвшүүлнэ.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдснаар зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, чиглэл, удирдлага, үйл ажиллагаатай болж, тээврийн шинэ төрөл хөгжих боломж бүрдснээр салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэж, эдийн засаг, нийгмийн бусад салбаруудын хөгжлийг хангагч гол тулгуур салбар болон хөгжих боломж бүрдэнэ.

Олон улсын тээврийн коридорыг төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэх замаар найдвартай, хямд, үр ашигтай тээврийн нэгдсэн сүлжээг бий болгох боломж бүрдэнэ.

Зам тээврийн нэгдсэн сүлжээ бий болсноор гадаад худалдааны эргэлт өсч, ажлын байр нэмэгдэх ба үүнийг дагаад эдийн засгийн өсөлт бий болж, үндэсний баялаг нэмэгдэх бөгөөд түүнчлэн чанартай, шуурхай, аюулгүй, мэргэжлийн өндөр түвшний тээврийн үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Тээврийн нэгдсэн эрх зүйн орчин бүрдснээр Монгол Улс Ази-Европ тивийг холбосон газар зүйн байрлалын давуу талаа ашиглан олон улсын худалдаа, тээвэр, логистикийн нэгдсэн зангилаа төв болох замаар олон улсын худалдаа, тээвэр, логистикийн зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засаг, нийгмийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой болно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд тээврийн үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай холбогдуулан Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Далайн ашиглах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулан холбогдох өөрчлөлтүүдийг оруулна.

- оОо -